



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/004/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn
Аудитор: Н.Батжаргал
Утас: 70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1 ЗӨВЛӨМЖ	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2025.03.13 № 139

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН БУЯНТ ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
Н.БАТЗАЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Буянт өрхийн эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр "Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл" хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Эмийн үлдэгдлийн хянаж үзэхэд он дамжин эхний үлдэгдлээр тайланд тусгагдсан, бодитой оршин байхгүй 43,760.8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бараа материалын тайланд бүртгэлтэй;

8426050574

- ✓ Нийт зардлаас түүвэрлэн хянахад 3,483.0 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй,
- ✓ Томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас тайлангүй, томилолтын тооцоо бодоогүй 500.0 мянган төгрөгийн зардал санхүүжүүлсэн,
- ✓ Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл олгосон;

Асуудлыг онцолсон хэсэг

Өрхийн эрүүл мэндийн төв нь орон нутгийн өмч ашиглан зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хэлбэрээр ажиллаж байгаа боловч эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг эрх бүхий этгээдээр батлуулаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Жаргалант сумын Буянт өрхийн эрүүл мэндийн төв нь 447,582.7 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийг Жаргалант сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар болон аймгийн Эрүүл мэндийн газраас хүлээн авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 10 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 98.7 хувьтай үнэлэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэгсэлгүйн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	120,830	3,417,026.00
1.1.2	Дансны авлага	33,450,803	6,134,673.50
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага.цалин хөлс	263,130	500,000.00
1.1.4	Бусад авлага.тооцооны данс	38,527	40,000.00
1.1.6	Бараа материал	103,008,392	84,323,112.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,881,682	94,414,811.75
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	150,820,278	527,741,395.87
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	150,820,278	527,741,395.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	287,701,960	622,156,207.62
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	7,017,482	
2.1.1.3	Татварын өр	6,924,716	6,166,188.03
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	80,000	920,900.69
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,022,198	7,087,088.72
2.2	Өр төлбөрийн нийт дүн	14,022,198	7,087,088.72
2.3	Эздийн өмч	23,837,746	23,837,746.00
2.3.1	Өмч: - төрийн	23,837,746	23,837,746.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	30,749,300	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	43,361,900	43,361,900.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	110,515,069	197,922,288.63
2.3.10	Тайлант үеийн ашиг/алдагдал/	65,215,747	349947184.27
2.3.11	Эздийн өмчийн дүн	273,679,762	615,069,118.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	287,701,960	622,156,207.62

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12 сарын 31 өдөр
1	Борлуулалтын орлого (цэвэр)	470,604,417	538,109,624.70
3	Нийт ашиг (алдагдал)	470,604,417	538,109,624.70
8	Бусад орлого/Үнэ төлбөргүй авсан /	9,025,115	453,096,045.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	414,413,785	598,018,201.43
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(30,760,020.00)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(12,480,264.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	65,215,747	349,947,184.27
20	Татварын дараах ашиг (алдагдал)	65,215,747	349,947,184.27
24	Орлогын нийт дүн	65,215,747	349,947,184.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,837,746.0	30,749,300.0	43,361,900.0	175,730,816.0	273,679,762.0
3	Залруулсан үлдэгдэл	23,837,746.0	30,749,300.0	43,361,900.0	175,730,816.0	273,679,762.0
9	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,837,746.0	30,749,300.0	43,361,900.0	175,730,816.0	273,679,762.0
11	Залруулсан үлдэгдэл	23,837,746.0	30,749,300.0	43,361,900.0	197,922,288.6	295,871,234.6
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				349,947,184.3	349,947,184.3
14	Өмчид гарсан өөрчлөлт		(30,749,300.0)			(30,749,300.0)
17	2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,837,746.0	-	43,361,900.0	547,869,472.9	615,069,118.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	470,604,417	565,425,754.20
1.1.1	Орон нутгийн төсвийн санхүүжилт/Тогтмол зардал/	5,858,797	15,140,572.00
1.1.2	Бусад төсөл хөтөлбөр/ЭМГ-Оношлуур/		3,000,000.00
1.1.3	Жаргалант сум/хүүхдийн сувилал/	2,000,000	1,800,000.00
1.1.4	ЭМД Санхүүжилт	85,769,500	141,023,078.00
1.1.5	НИТЗ санхүүжилтийн орлого	376,869,618	392,491,464.40
1.1.6	Бусад мөнгөн орлого/Банкны хүү/	106,502	11,970,639.80
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	470,530,399	562,129,558.20
1.2.1	Ажиллагчдад төлсөн	270,462,920	318,099,766.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	80,651,472	89,411,219.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	57,485,337	46,813,069.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,897,320	15,159,245.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,814,600	5,303,000.00
1.2.6	Төсөл хөтөлбөр.тэтгэмж	2,000,000	3,000,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	24,924,903	45,848,753.00
1.2.8	Шуудан холбоо интернэтэд төлсөн	1,242,301	1,430,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	23,051,546	37,064,006.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	74,018	3,296,196.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	74,018	3,296,196.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,812	120,830.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	120,830	3,417,026.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 82,518.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 30,943.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардлыг илүү тусгасан 30,943.5 мянган төгрөгийг бүртгүүлэв.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 51,583.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд 51,583.8 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Анхан шатны баримтын бүрдэл, бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Зарим худалдан авалтыг төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, томилолтоор ажилласан тухай илтгэх хуудас тайлангүй, томилолтын тооцоо бодоогүй 3,983.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээний анхан шатны баримтыг иж бүрэн бүрдүүлж, дотоод хяналтыг сайжруулан ажиллах

3.1.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад эрх бүхий дээд шатны удирдлагын тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл олгосон 3,840.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.12-т "Эрүүл мэндийн байгууллагын даргын ажлын үр дүнг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өрхийн эрүүл мэндийн төвийн даргад олгох улирлын үр дүнгийн нэмэгдлийг дээд шатны байгууллагын удирдлагаар тушаал шийдвэр гаргуулан олгох.

3.1.3 Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эмийн үлдэгдлийн хянаж үзэхэд он дамжин эхний үлдэгдлээр тайланд тусгагдсан, бодитой оршин байхгүй зүйлс бүртгэлтэй байгаа 43,760.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д

"Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эмийн үлдэгдэлд дотоод хяналт хэрэгжүүлэн, тооцоог бодож, холбогдох арга хэмжээг авах, цаашид эмийн зарцуулалтыг үнэн зөв тооцож хэвших.

3.1.4 Газартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ байр, хашааны болон гадна зогсоолын газрыг шийдвэр гаргуулж бүртгэлд тусгаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Журам шинэчлэн батлах тухай" 271 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.8-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшиж байгаа газрыг шийдвэр гаргуулан бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Буянт ӨЭМТ	Санхүүгийн тайланд үйл ажиллагааны орлого, зардлыг дутуу тусгасан	1	30,934.5			1		1	30,934.5				
Нийт дүн		1	30,934.5			1		1	30,934.5				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хуульд	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Буянт ӨЭМТ	Эмийн үлдэгдэлд бодитой оршин байхгүй зүйлс бүртгэлтэй байна.	1	43,760.8					1	43,760.8		
	Тушаал шийдвэргүйгээр улирлын үр дүнгийн нэмэгдэл олгосон	1	3,840.0					1	3,840.0		
	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	3,983.0					1	3,983.0		
	ЭӨМТ-ийн гаурыг бүртгэлд тусгаагүй	1	0					1	0		
Нийт дүн		4	51,583.8					4	51,583.8		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

